БАТЛАВ.
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА

Ж.ЦОЛМОН

8112738 ШТЖ1492 9025011078

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ

Баримт бичгийн код	**АХОЗШША** - 25-19		
Баталсан огноо:	2025 он- 12 сар- 16 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр Х. Нарангуа	Огноо 2025. 12. 15	Гарын үсэг
Боловсруулсан:	Албан тушаал, нэр Г. Гантуяа	Огноо 2025. 12. 15	Гарын үсэг

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Шинэ хууль, дүрэм	Бүгд	Шинжлэн шалгагч	2025. 12. 16	
2					
3					

Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Журам	Шинжлэн шалгагч нарт
2		
3		

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Чикагогийн конвенцын Хавсралт 13-ын дагуу агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа явуулах байгууллагын үйл ажиллагаа, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх хангалттай боловсон хүчинтэй байх, шинжлэн шалгагч нарыг ажиллуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ажиллагааг зохицуулна.
1.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (цаашид “АХОЗШША” гэх)-аас шинжлэн шалгагч сонгон шалгаруулж томилох, мөн гаднын байгууллагаас шинжлэн шалгагч, мэргэжилтэн авч оролцуулахад ICAO-ийн Doc 9756, Doc 9734, Doc 9962 бичиг баримтад заасан зааврыг мөрдлөг болгоно.

2. Бүтэц, зохион байгуулалт ба эрх зүйн үндэслэл

2.1. Бүтэц ба хараат бус байдал

2.1.1. ICAO-ийн Конвенцын 26 дугаар зүйлд заасны дагуу агаарын хөлгийн осол гарсан улс ослын нөхцөл байдлыг шинжлэн шалгах үүрэгтэй. Энэхүү үүргийг хэрэгжүүлэхийн тулд шинжлэн шалгах байгууллага нь нисэхийн эрх бүхий байгууллага болон бодит байдалд саад учруулж болзошгүй бусад байгууллагаас хараат бус байна.
2.1.2. АХОЗШША нь үнэнч шударга, улс төрийн болон бусад хөндлөнгийн оролцоо, дарамтгүй ажиллах байгууллагын зарчмыг баримтална.
2.1.3. Хавсралт 13-ын дагуу шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах, явуулах, хяналтыг хариуцах хариуцсан шинжлэн шалгагчийг томилно. Хариуцсан шинжлэн шалгагч нь ослын шинжлэн шалгах байгууллагаас байх нь зохистой.
2.1.4. Шинжлэн шалгах багт шаардлагатай тохиолдолд бусад байгууллагаас томилогдсон мэргэжилтэн, сэдвийн шинжлэн шалгагчийг татан оролцуулж болох бөгөөд шинжлэн шалгах хугацаанд тэд хариуцсан шинжлэн шалгагчийн өмнө хариуцлага хүлээнэ.

2.2. Байгууллагын орон тоо (бүтэц)

2.2.1. АХОЗШША нь нийт 12 орон тоотой байна. Үүнээс шинжлэн шалгах чиг үүрэгтэй 7 (даргыг оролцуулан) албан тушаал, захиргаа-судалгааны чиг үүрэгтэй 5 албан тушаал тус тус байна.

Нэгж	Албан тушаал	Тоо	Тайлбар
Удирдлага	Дарга, ерөнхий шинжлэн шалгагч	1	Нийт багийг удирдах
Шинжлэн шалгах тасаг	Ахлах шинжлэн шалгагч	1	Багийн ахлагч/чиглүүлэгч
Шинжлэн шалгах тасаг	Нислэгийн шинжлэн шалгагч	2	Нислэгийн үйл ажиллагаа
Шинжлэн шалгах тасаг	Нислэгийн хөдөлгөөний шинжлэн шалгагч	1	ATC/ANS
Шинжлэн шалгах тасаг	Техникийн шинжлэн шалгагч	2	Агаарын хөлөг, техник, засвар үйлчилгээ

Захиргаа, судалгааны тасаг	Санхүү, нягтлан бодогч	1	
Захиргаа, судалгааны тасаг	Бүртгэл, судалгааны мэргэжилтэн	1	Мэдээлэл судалгаа
Захиргаа, судалгааны тасаг	Гадаад харилцаа, хуулийн мэргэжилтэн	1	MoU/эрх зүйн дэмжлэг
Захиргаа, судалгааны тасаг	Бичиг хэрэг, туслах ажилтан	1	
Захиргаа, судалгааны тасаг	Технологийн жолооч	1	Шуурхай гаргалт, логистик

2.3. Хууль эрх зүй

2.3.1. АХОЗШША нь Иргэний нисэхийн тухай хуулийн 9 дүгээр бүлэгт заасан эрх зүйн үндэслэлээр бие даасан, хараат бус үйл ажиллагааг явуулна.
2.3.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг Конвенцын 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага гүйцэтгэнэ.

2.4. Санхүүжилт

2.4.1. АХОЗШША нь өөрийн хариуцах хүрээнд хамаарах осол, зөрчлийг зохих ёсоор шинжлэн шалгахад хангалттай хөрөнгөтэй байна. Төсвийн шаардлагыг урьдчилан нарийн тооцоолох боломжгүй тохиолдолд шаардлагатай нэмэлт санхүүжилтийг холбогдох журмын дагуу шийдвэрлүүлнэ.
2.4.2. Мэргэшсэн техникийн ажилтныг ажилд авах, хадгалах зорилгоор өрсөлдөх чадвартай цалин хөлс, ажлын нөхцөл, урт хугацааны бодлогыг хэрэгжүүлнэ.

3. Ажилтнуудын шаардлага ба мэргэшил

3.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах нь тусгай мэргэшлийн ажил бөгөөд зөвхөн мэргэшсэн шинжлэн шалгагчид гүйцэтгэнэ.
3.2. Шинжлэн шалгагч нь нисэхийн чиглэлээр практик туршлагатай (нисгэгч, нисэхийн инженер, засвар үйлчилгээний инженер, нислэгт тэнцэх чадвар, ATC/ANS, хүний хүчин зүйлс гэх мэт) байх бөгөөд тасралтгүй сургалт, давтан бэлтгэлд хамрагдана.
3.3. Шинжлэн шалгагч нь баримтыг үнэн зөв бүртгэх, дүн шинжилгээ хийх, хүнд нөхцөлд тууштай ажиллах, олон талт оролцогч талуудтай ёс зүйтэй харилцах зэрэг хувийн ур чадвар, зан төлөвийн шаардлагыг хангана.

4. Шинжлэн шалгагчийн хэрэгцээг тодорхойлох арга зүй

4.1. Ерөнхий зарчим

4.1.1. Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлохдоо Монгол Улсад бүртгэгдсэн осол, зөрчлийн статистик, үйл ажиллагааны хэмжээ, нарийн төвөгтэй байдал, хамрах техникийн чиглэлүүдийг харгалзан үзнэ.

4.1.2. Томоохон, нарийн төвөгтэй ослын үед (харилцан тохиролцсон тохиолдолд) шинжлэн шалгах ажиллагааг өөр улсын ослын шинжлэн шалгах байгууллагад шилжүүлэх, эсхүл гаднын мэргэжилтэн, нөөц шинжлэн шалгагч татан оролцуулах төлөвлөгөөтэй байна.

4.2. Ажлын ачаалал (man-hour) тооцоолол

4.2.1. Нэг шинжлэн шалгагчийн жилд ажиллах нийт цагийг дараах байдлаар тооцно:
X = Жилд ажиллах өдөр × Өдөрт ажиллах цаг.

Жилд ажиллах өдөр	Өдөрт ажиллах цаг	Жилд ажиллах нийт цаг (X)
240	8	1920 цаг/жил

4.2.2. Жил бүр хийх дундаж шинжлэн шалгах ажиллагааны үргэлжлэх хугацаа (сар) болон тоо хэмжээг ашиглан нийт хэрэгцээт ажиллах цаг болон шаардлагатай шинжлэн шалгагчийн тоог тооцно.
Тайлбар:
X – Жилд ажиллах нийт цаг
Y – Нэг ажиллагаанд дундаж зарцуулах сар - 6;
Z – Жилд хийх дундаж ажиллагааны тоо - 4.
T–Жилд шинжлэн шалгагчдын сургалтад хамрагдах цаг/сургалтын төлөвлөгөөнөөс 5х5=25 хоног
K – Шинжлэн шалгагчдын ээлжийн амралтын цаг/5 шинжлэн шалгагч 5 х 14 хоног = 70 хоног/

Үзүүлэлт	Томьёо	Жишээ (X=1920, Y=6 сар, Z=4)
Нэг шинжлэн шалгах ажиллагаанд ноогдох ажиллах цаг	**$H_1 = X \times Y/12$**	**$H_1 = 1920 \times 8/12 = 1280$**
Жилийн нийт шинжлэн шалгах ажиллах цаг	**$H_2 = Z \times H_1$**	**$H_2 = 4 \times 1280 = 5120$**
Нийт цаг	**$H_3 = X\text{-}T\text{-}K$**	**$H_3 = 1920\text{-}200\text{-}560 = 1160$ цаг**
Шаардлагатай шинжлэн шалгагчийн тоо	**$N = H_2 / X$**	**$N = 5120/1160 = 4{,}4$** (дээш нь бүхэлдүүлнэ)

4.2.3. Тооцоолсон N утгыг бодит бэлэн байдлыг хангах үүднээс (ээлж, амралт, сургалт, томилолт, олон ажиллагаа давхцах эрсдэл) нэмэгдүүлэх коэффициент (жишээ нь 1.1–1.3) хэрэглэхийг зөвлөмжилнө. Коэффициентыг жил бүр удирдлагын шийдвэрээр тогтооно. /Хавсралт В/.

5. Бэлэн байдал, төлөвлөлт ба нөөц татан оролцуулах

5.1. Шинжлэн шалгах байгууллагын бэлэн байдал нь хууль тогтоомж, журам, хангалттай төсөв, туршлагатай ажилтнаас гадна бодлого, төлөвлөгөө, шалгах хуудас, харилцан ажиллагааны баримтжуулсан механизмуудаас хамаарна.

5.2. Томоохон ослын үед дотоод нөөц хүрэлцэхгүй байх эрсдэлийг бууруулах зорилгоор иргэний нисэхийн байгууллага, оператор, үйлдвэрлэгч, холбогдох төрийн байгууллагуудтай болон бусад улсын ослын шинжлэн шалгах байгууллагуудтай санамж бичиг /MoU/ гэрээ байгуулж, нөөц татан оролцуулах төлөвлөгөө боловсруулна.
5.3. Хавсралт 13-ын дагуу осол болсон улс нь шинжлэн шалгах ажиллагааг эхлүүлэх үүрэгтэй боловч харилцан тохиролцоогоор ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн өөр улсын ослын шинжлэн шалгах байгууллагад шилжүүлж болно.

6. Шинжлэн шалгагчийг сонгох, томилох, итгэмжлэх

6.1. Шинжлэн шалгагчийн сонгон шалгаруулалт нь мэргэжлийн шаардлага, туршлага, ур чадварын үнэлгээ, ёс зүйн шалгуур, ашиг сонирхлын зөрчилгүй байдлыг үндэслэнэ.
6.2. Шинжлэн шалгагчид төрийн байгууллагын үнэмлэх/итгэмжлэл олгож, эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хууль тогтоомжийн болон зохицуулалтын үндэслэлийг тодорхой тусгана. Үнэмлэх/итгэмжлэл нь шинжлэн шалгах ажиллагааны явцад хууль зүйн үндэслэл болно.
6.3. Гаднын байгууллагаас түр шилжүүлэн ажиллуулах (secondment) тохиолдолд: бичгээр гэрээ/санамж бичиг байгуулж, хараат бус байдал, ашиг сонирхлын зөрчилгүй байдлын мэдэгдэл, мэдээллийн нууцлал, үүрэг гүйцэтгэх хугацаанд үндсэн ажлын үүргээс чөлөөлөх нөхцөлийг тусгана.

7. Журмын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, шинэчлэлт

7.1. Энэхүү журмын хэрэгжилтийг АХОЗШША-ны дарга хариуцан зохион байгуулж, захиргаа, судалгааны тасаг жил бүр хүний нөөцийн хэрэгцээний тооцооллыг шинэчилж, тайлан танилцуулна.
7.2. Журмыг хэрэгжүүлэх явцад гарсан өөрчлөлт, сайжруулалтын саналыг жил бүр нэгтгэн, хувилбарын удирдлагын хүснэгтэд тэмдэглэн шинэчилнэ.

Хавсралт А. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭ ТОДОРХОЙЛОХ ЖИЛИЙН ЦИКЛ (загвар)

- А1. 1–2 дугаар сард өмнөх жилийн осол, зөрчлийн статистик, тайлан, сургалтын бүртгэлийг нэгтгэнэ.
- А2. 3 дугаар сард man-hour тооцооллыг шинэчилж, чадамжийн цоорхой (specialty gap)-г үнэлнэ.
- А3. 4 дүгээр сард орон тоо, сургалт, нөөц татан оролцуулах төлөвлөгөөг удирдлагаар батлуулна.
- А4. Жилийн турш хэрэгжилтийг хянаж, шаардлагатай үед нэмэлт санхүүжилт/нөөцийн хүсэлт гаргана.

Шинжлэн шалгагчийн мэргэшлийн матриц (загвар)

Хүснэгт 1

Овог нэр	Үндсэн мэргэжил	Осол шинжлэн шалгах сургалт	Нислэг/АТС/ Техник чиглэл	Сүүлийн 12 сард оролцсон ШШ ажиллагаа	Тайлбар

Тайлбар: Матрицыг ажилтны бодит мэдээллээр бөглөж, чадамжийн цоорхойг тодорхойлоход ашиглана.

Хавсралт В. Ажлын ачаалал (man-hour) тооцоолол

4.2.1. Нэг шинжлэн шалгагчийн жилд ажиллах нийт цагийг дараах байдлаар тооцно:
X = Жилд ажиллах өдөр × Өдөрт ажиллах цаг. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Жилд ажиллах өдөр	Өдөрт ажиллах цаг	Жилд ажиллах нийт цаг (X)

4.2.2. Жил бүр хийх дундаж шинжлэн шалгах ажиллагааны үргэлжлэх хугацаа (сар) болон тоо хэмжээг ашиглан нийт хэрэгцээт ажиллах цаг болон шаардлагатай шинжлэн шалгагчийн тоог тооцно.
Тайлбар: Y – нэг ажиллагаанд дундаж зарцуулах сар; Z – жилд хийх дундаж ажиллагааны тоо. (Хүснэгт 3)

Хүснэгт 3

Үзүүлэлт	Томьёо	Жишээ (X=1920, Y=6 сар, Z=4)
Нэг ажиллагаанд ноогдох ажиллах цаг	$H_1 = X \times Y/12$	$H_1 = 1920 \times 8/12 = 1280$

Жилийн нийт шинжлэн шалгах ажиллах цаг	$H_2 = Z \times H_1$	$H_2 = 4 \times 1280 = 5120$
Шаардлагатай шинжлэн шалгагчийн тоо	$N = H_2 / X$	$N = 5120/1160 = 4,4$ (дээш нь бүхэлдүүлнэ)

4.2.3. Тооцоолсон N утгыг бодит бэлэн байдлыг хангах үүднээс (ээлж, амралт, сургалт, томилолт, олон ажиллагаа давхцах эрсдэл) нэмэгдүүлэх коэффициент (жишээ нь 1.1–1.3) хэрэглэхийг зөвлөмжилнө. Коэффициентыг жил бүр удирдлагын шийдвэрээр тогтооно.

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ АЖЛЫН АЧААЛАЛ (MAN-HOUR) ТООЦООЛОЛ

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны жилд хийх дундаж шинжлэн шалгах ажиллагааны тоог 6 гэж үзвэл албаны шинжлэн шалгагч нарын ажлын ачааллын (man-hour) тооцоолол дараах байдлаар гарна.

Ажлын ачаалалын тооцоолол:
X - Жилд ажиллах нийт цаг
Y - Нэг шинжлэн шалгах ажиллагаанд дундаж зарцуулах сар - 6
Z - Жилд хийх дундаж шинжлэн шалгах ажиллагааны тоо – 4
T – Жилд шинжлэн шалгагчдын сургалтад хамрагдах цаг/сургалтын төлөвлөгөөнөөс 5х5 = 25 хоног
К - шинжлэн шалгагчдын ээлжийн амралтын цаг/ 5 шинжлэн шалгагч 5 х 14 хоног = 70 хоног

Жилд ажиллах өдөр - 240 өдөр

Өдөрт ажиллах цаг - 8 цаг

X = Жилд ажиллах өдөр × Өдөрт ажиллах цаг

X = 240 х 8 = 1920 цаг

H_1 - Нэг шинжлэн шалгах ажиллагаанд ноогдох ажиллах цаг
H_2 - Жилийн нийт шинжлэн шалгах ажиллагаанд ажиллах цаг
N - Шаардлагатай шинжлэн шалгагчийн тоо

H_1 = X×Y/12 = 1920х8/12=1280 цаг

H_2 = Z×H_1 = 4 × 1280 = 5120 цаг

H_3 = X – T – К =1920-200-560=1160

N = H_2 / X = 5120/1160 = 4,4

Албанд шаардлагатай шинжлэн шалгагч нарын тоо **4,4** гэж байгаа бол их бол 5-6 шинжлэн шалгагч шаардлагатай болно.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

Захиргаа, судалгааны тасаг, Техникийн шинжлэн шалгагч П.Гэрэлчимэг

Холбоо барих утас: 7128-5099

Цахим шуудан: gerelchimeg@aaib.gov.mn